

2025 оны

үйл ажиллагааны
тайлан

Агуулга



01. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны тухай
02. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц, зохицуулалтын орчинг сайжруулах тухай
03. Холбооны үндсэн үйл ажиллагааны тухай

Товчилсон үгийн жагсаалт

ААН – Аж ахуйн нэгж

ББСБ – Банк бус санхүүгийн байгууллага

ББЗЗ – Биржийн бус зах зээл

БНСУ – Бүгд Найрамдах Солонгос Улс

ГШХО – Гадаадын шууд хөрөнгө оруулалт

ДНБ – Дотоодын нийт бүтээгдэхүүн

ЗГҮЦ – Засгийн газрын үнэт цаас

ЗЗ – Зээлжих зэрэглэл

ЖДҮ – Жижиг дунд үйлдвэр

МУТСТС – Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх систем

МУ – Монгол Улс

МҮЦАЭХ – Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

МҮЦКТ – Монголын үнэт цаасны клирингийн төв

МХБ – Монголын хөрөнгийн бирж

НББ – Нягтлан бодох бүртгэл

НХБ – Нэгдсэн хөрөнгийн багц

ХОМК - Хөрөнгө оруулалтын менежментийн компани

ҮЦТХТ – Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

ОУ – Олон улс

СЗХ – Санхүүгийн зохицуулах хороо

ТББ – Төрийн бус байгууллага

Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо 2025 оны тайлангаа хүргэж байгаа энэ өдрийн мэндийг зах зээлд оролцогч, гишүүн байгууллага Та бүхэндээ хүргэе. Холбоо нь хөрөнгийн зах зээл хөгжил, гишүүн байгууллагуудын эрх ашгийн хамгаалах, ёс зүйн хэм хэмжээг өндөрт байлгахын төлөө хүчин чармайлт гарган ажиллаж байна. Өнгөрөгч 2025 онд холбооны зүгээс өмнөх жилүүдэд хийж бүтээж байсан амжилтаа бататгах, алдаа дутагдлаа засах, шинэ санаа санаачлаг гаргах, үр дүнд хүрэх чиглэл дээр ихээхэн анхааран ажиллаа.

Бидний өмнө цаашид зах зээлийн хөрвөх чадварын сайжруулах, гадаад дотоод хөрөнгө оруулалтыг татах, банкны системээс илүү гарсан зах зээлийг бий болгох, нээлттэй, ил тод байдал, засаглалыг сайжруулах, хөрөнгө оруулагч нарын эрх ашгийг хамгаалах, олон улсын стандартыг нэвтрүүлэх зэрэг олон талт хамтын ажиллагааг төр болон хувийн хэвшилтэй хамтран хийж гүйцэтгэх ажлууд хүлээгдэж байна. Бидний үндсэн үйл ажиллагааны хэсэг болох хөрөнгийн зах зээлд ажиллах эрхийн сургалтыг зохион байгуулах, биржийн бус зах зээл дээрх бондын бүртгэлийг богино хугацаанд чанартай гүйцэтгэх дээр мөн анхаарал хандуулан ажиллалаа.

Өнгөрөгч 2025 онд биржийн бус зах зээлд төгрөгөөр **2,385.1 тэрбум**, ам.доллороор **84 сая** үнийн дүн бүхий бонд бүртгэгдэж, үүнээс **1,589.6 тэрбум** төгрөг, **63.9 сая** ам.долларын бонд амжилттай татан төвлөрүүлснээр бодит эдийн засагт хувь нэмрээ орууллаа. Үнэт цаас гаргагч нарын ажиллаж буй салбар зөвхөн санхүүгийн салбараар хязгаарлагдахгүй уул уурхай, барилга, гадаад худалдаа зэрэг салбарт хүрсэн нь онцлох жил байлаа. Зах зээлд ажиллах дараагийн боловсон хүчнээ бэлдэхэд чухал нөлөө үзүүлдэг хөрөнгийн зах зээлд ажиллах эрхийн бичгийн сургалтад нийт 376 хүн хамрагдаж үүнээс 38 зуучлалын эрх, 157 хөрөнгө оруулалтын эрх 11 уул уурхайн брокерын эрх тус тус авсан байна.

Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ

Бодлого боловсруулагч болоод бодлого тодорхойлогч нартай өнгөрсөн жил холбооны зүгээс илүү ойр хамтран ажиллалаа. Тухайлбал холбооны зүгээс Улсын Их хуралд суудалтай нэр бүхий намын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулахаас гадна УИХ-н даргын захирамжаар “Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн судалгаа цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх” ажлын хэсэг байгуулуулж хөрөнгийн зах зээлд тулгамдаж буй асуудлуудыг ойлгуулах тал дээр ихээхэн анхааралтай хандууллаа.

Түүнчлэн, зохицуулагч байгууллагуудаас баталдаг аливаа эрх зүйн болон дүрэм, журмын өөрчлөлтийг нийт гишүүн байгууллагуудаас урьдчилан санал авсаны үндсэн дээр баталдаг соёлыг суулгасан нь чухал алхам байлаа. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах үүднээс холбоо бусад мэргэжлийн холбоодуудтай нэгдэж “Соёмбо” бизнесийн нэгдсэн холбоог үүсгэн байгуулж цаашид бодлого тодорхойлогч нарт хувийн хэвшлийн дуу хоолой хүргэхийн сацуу эрх ашигийн хамгаалах зорилготой хамтын ажиллагааг эхлүүллээ.

Мөн Санхүү Эдийн Засгийн Их сургуультай хамтарч “Хөрөнгийн зах зээлийн хөгжил бодлогын судалгаа 2025” судалгааг хийсэн нь Холбооны дараагийн алхам буюу гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарыг хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг санхүүгийн болон санхүүгийн бус аргаар дэжих суурь судалгаа байсан юм.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламийн төвтэй хамтарч бэлэн мөнгөний гүйлгээг зарлагын хэмжээнээс үл хамааран цахимжуулсан нь хожуу байсан ч томоохон дэвшил байсан гэж бодож байна.

Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ


Дотоод зах зээлд мэргэжлийн цөөн хөрөнгө оруулагч нарын нэг болох арилжааны банкуудыг хөрөнгийн зах зээл рүү татах чиглэлийн хүрээнд Монголбанкны холбогдох журамд өөрчлөлт оруулж цаашид банкны тухай хуульд өөрчлөлт оруулах боломж эрэлхийлсэн жил байлаа. Ирэх 2026 онд холбооны зүгээс Монголбанк болон бусад байгууллагатай хамтран Засгийн газрын үнэт цаасны “primary” арилжааг эхлүүлэх, мөнгөний зах зээлийг илүү сайн хөгжүүлэх чиглэлд ажиллах нөхцөл боломж 2025 онд бүрдсэн гэж найдаж байна.

Холбоо нь Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкттай хамтрач гадаадын хуулийн этгээдийг Монгол улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах боломжийг хялбаршуулах үүднээс харилцагчийг танин мэдэх аргачлал дээр хамтран ажиллалаа.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн нэг тулгуур болох ил тод, нээлттэй байдал, засаглалыг сайжруулах үүднээс гадаад, дотоодын хандивлагч байгуулуудтай хамтарч Edis-Mongolia / electic disclosure information system/ -г нэвтрүүлэх суурь тавигдсан жил байлаа.

Уул уурхайн биржийн тухай хуулийн хоёрдмол утгай заалтуудаас шалтгаалж холбооны гишүүн болон гишүүн бус байгууллагуудын хөрөнгө оруулалт царцах, алдагдсан боломж өсөх зэрэг сөрөг үр дагаварыг халах үүднээс төр, хувийн хэвшлийн олон талт үйл ажиллагааг хийснээр ирэх жил уул уурхайн биржийн арилжаа зуучлагч буюу брокер луу бүрэн шилжинэ гэж найдаж байна.

Эцэст нь Монгол улсын хөрөнгийн зах зээлийн Азийн болон бусад улс орнуудад таниулж сурталчилсан “Asia Securities Forum 2025”-г холбооны зүгээс амжилттай зохион байгуулсан нь өнгөрөгч оны томоохон үйл явдал байсан юм.

A grayscale photograph of a jagged mountain peak, likely Mount Everest, with a bright light source on the left creating a lens flare effect. The mountain's surface is highly textured with sharp ridges and deep shadows.

1.1. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны тухай



Хөрөнгө оруулагчид болон гишүүн байгууллагуудын нийтлэг эрх ашгийг хамгаалж ёс зүйн стандартыг тогтоож шударга, ил тод, нээлттэй зах зээлийг бүрдүүлэн хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийг бий болгох зорилгын доор 2025 оны ажлын тайланг хүргэж байна.

Байгуулагдсан он:

1995

ӨЗБ болсон:

2015

Бусад улсын гишүүнчлэл:



2025 онд 96 байгууллага байгаагаас 72 нь мэргэжлийн буюу саналын эрхтэй, үлдсэн 24 нь дэмжигч буюу саналын эрхгүй гишүүд байна.

- Эм Ай Ди Эй Эс ҮЦК ХХК - Мэргэжлийн
- М секьюритис ҮЦК ХХК - Мэргэжлийн
- Тидиби ассет менежмент ХХК - Мэргэжлийн
- Өмгөөллийн легал гайд ХХК- Дэмжигч
- Дижитал маркет ББСБ - Дэмжигч
- Өмгөөллийн Вайт Крест партнерс ХХК- Дэмжигч
- Өмгөөллийн Аллисон энд Кэйт ХХН- Дэмжигч
- Өмгөөллийн сноу хилл ХХК- Дэмжигч
- Өмгөөллийн Эм Ай Си Жи ХХК- Дэмжигч тус тус гишүүнээр элсүүлэв.

46

Үнэт цаасны компани

23

Хөрөнгө оруулалт менежментийн компани

05

Дэд бүтцийн байгууллага

05

Банк

03

Хувьцаат компани

01

Үнэлгээний компани

01

Олон улсын байгууллага

10

ҮЦЗЗ оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх

02

Санхүүжих чадварын зэрэглэл тогтоох байгууллага

72 МЭРГЭЖЛИЙН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

24 ДЭМЖИГЧ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

96

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Г.ЭНХБАТ

2025 онд Удирдах зөвлөлийн гишүүд нийт **16** удаа хуралдаж, **44** тогтоол гаргасан байна.

ГИШҮҮД:



Д.БААТАРЖАВ



Л.БИЛГҮҮН



Т.БОЛД



С.ГАН-ЭРДЭНЭ



Б.ЛХАМДОЛГОР



М.ОТГОНБААТАР



А.ӨЛЗИЙДЭЛГЭР

ХАРААТ БУС ГИШҮҮД:



Э.ЗОЛБАЯР



А.ХУЛАН



Ц.СОДХҮҮ

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



С.ЖАВХЛАН

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:



Ё.АМАРБАТ



Ч.АНДСАЙХАН



С.БАЯРХҮҮ



Ч.НЯМДОРЖ



У.ЭНХТАЙВАН



Ж.ЭРДЭНЭБАТ

A 3D rendered landscape of jagged, grey mountains under a dark, cloudy sky. A bright light source on the left creates a lens flare effect. The foreground shows dark green, forested slopes.

2.1. Хууль эрх зүйн орчинг ДЭМЖИХ

2.1.1. Холбооны дүрэм журмын өөрчлөлт

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо хамтран “Бонд Форум 2025” арга хэмжээг зохион байгуулж, Топ-100 аж ахуйн нэгжийг хөрөнгийн зах зээлд оролцуулах, үнэт цаас гаргах үйл ажиллагааг дэмжих хүрээнд тавигдах шалгууруудыг багасгаж, “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулав.

Уг өөрчлөлтийн хүрээнд Топ-100 аж ахуй нэгжээр шалгарсан компани нь нэг жилээс бага хугацаатай, 5 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл гаргах бол андеррайтертай гэрээ байгуулахгүй, барьцаа, баталгаагүй гаргах боломжтой боллоо.

Үүргийн гүйцэтгэл хангуулагчтай гэрээ байгуулсан, урьдчилан тохиролцсон 5 хүртэлх хөрөнгө оруулагчтай үнэт цаасыг Бүртгэлийн хорооны орон тооны гишүүний шийдвэрээр бүртгэх зохицуулалтыг тусгав.

Түүнчлэн олон улсын санхүүгийн байгууллага үнэт цаас гаргах тохиолдолд төслийн танилцуулга, үнэт цаас гаргагчид тавигдах шалгуур, мэдээлэх үүргээс чөлөөлөх зохицуулалтыг тусган бүртгэлийн үйл явцыг хялбаршуулж, хугацааг богиносгон зах зээлийн үйл ажиллагааны үр ашиг, санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн.

БҮРТГЭЛИЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Бүртгэлийн хорооны үйл ажиллагааны журамд гишүүд шийдвэр гаргахдаа хууль, дүрэм, журмыг баримталж, хариуцлагатай, мэргэжлийн түвшинд ажиллах үндсэн шаардлагуудыг тодорхой тусгасан. Үүнд, хорооны гишүүд хурлын өмнө хэлэлцэх асуудлын материалтай урьдчилан танилцаж, баримтад үндэслэн санал, асуулт тавих, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл авах боломжийг бүрдүүллээ.

Эдгээр зохицуулалт хэрэгжсэнээр шийдвэр гаргалт илүү үндэслэлтэй, ил тод болж, шийдвэрийн чанар сайжрах нөхцөл бүрдэж байна. Мөн журамд заасан зарчмыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох тодорхой механизмыг тусгаснаар хяналт, хариуцлагын тогтолцоо бэхжиж, Бүртгэлийн хорооны үйл ажиллагааны сахилга бат, үр нөлөө цаашид сайжрах бодит боломж бүрдлээ.

2.1.1. Холбооны дүрэм журмын өөрчлөлт

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЖУРАМ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 448 тоот тогтоолоор “Биржийн бус зах зээлийн арилжааны журам” батламжлагдаж, 2025 оны 12 сарын 15-ны өдрөөс эхлэн ББЗЗ-н арилжааг 24/5 горимд шилжүүлж Даваа гарагийн 09:00 цагаас Баасан гарагийн 17:00 цаг хүртэл тасралтгүй зохион байгуулж эхэллээ. Зохицуулалтыг хялбар, боловсронгуй болгох үүднээс “Биржийн бус зах зээлийн ерөнхий журам” болон “Биржийн бус зах зээлийн арилжааны багц журам”-ыг нэгтгэн шинэчлэн найруулсан ба Биржийн бус зах зээлийн арилжааг блокчэйд суурилсан арилжааны системд шилжүүлж буйтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг тусгасан.



Уг зохицуулалтын хүрээнд OTC.mn арилжааны системийг 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар хэлэлцэж, 09 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн биржийн бус зах зээлийн арилжааг блокчэйд бүрэн шилжүүлсэн. Үүний үр дүнд төлбөр тооцоо автомат хэлбэрт шилжсэнээр хоёрдогч зах зээлийн арилжааны идэвх 40 хувиар өссөн байна.

2.1.2. Зах зээлийн судалгаа, бодлогын баримт бичиг

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ БОДЛОГЫН СУДАЛГАА

Холбооны зүгээс санаачлан Санхүү эдийн засгийн сургуулийн профессорууд болон зах зээлийн судлаачидтай хамтран Монгол Улсын хөрөнгийн захын хөгжлийг үнэлж, саад болж буй гол шалтгаануудыг тодорхойлон, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх бодлогын шийдлүүдийг эрэлхийлсэн судалгааг хийж гүйцэтгэлээ.



2.1.2. Зах зээлийн судалгаа, бодлогын баримт бичиг

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ЗАН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хороо болон Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургууль нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, цаашдын хөгжлийн чиглэл, бодлогын арга хэмжээ, хөрөнгө оруулагчдын зан төлөвийг тодорхойлох зорилготой хөрөнгө оруулагчийн зан төлөвийн судалгааг явуулсан. Судалгааны үр дүнг бодлого боловсруулагчид, зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд ашиглах бөгөөд Олон улсын ICBISD 2025 эрдэм шинжилгээний зөвлөгөөнд хэлэлцүүлэхээр төлөвлөсөн. Судалгаанд үнэт цаасны компаниудын оролцоог хангах зорилгоор:

- Холбооны танхимд судалгаа авах уулзалт зохион байгуулсан
- Судалгааг нээлттэй зарлаж, Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн 20 ҮЦК нар луу болон холбооны гишүүн үнэт цаасны компаниудад албан бичиг, имэйл мэдэгдэл хүргүүлж, утсаар холбогдон судалгаанд идэвхтэй хамруулсан.

Үүний үр дүнд судалгаанд оролцох байгууллагуудын оролцоо нэмэгдэж, судалгааны мэдээллийн бодит байдал, чанар хангагдсан. ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зах зээлийг хөгжүүлэх чиг үүргийн хүрээнд Номадикс хуулийн фирмтэй хамтран зах зээлийн эрх зүйн орчны судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүн, хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг үндэслэн хөрөнгө оруулалтын сан, ялангуяа гэрээний сантай холбоотой татварын бодлого, КҮС/AML-ийн хэрэгжилтэд үүсэж буй эрх зүйн тодорхойгүй байдлыг шийдвэрлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Монгол Банк болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг эхлүүлээд байна.

Энэ хүрээнд татварын ил тод зарчим, КҮС/AML-ийн зөрчил, давхардал, гэрээний сангийн үүсгэн байгуулалтын зохицуулалт, татварын нэг мөр ойлголтыг тодорхойлох чиглэлээр санал, тайлбар боловсруулж байгаа бөгөөд уг ажлыг 2026 онд үргэлжлүүлэн гүйцэтгэхээр төлөвлөж байна.

2.1.2. Зах зээлийн судалгаа, бодлогын баримт бичиг

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА, БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖИЛ

ХОМК нь хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зах зээлийг хөгжүүлэх чиг үүргийн хүрээнд Номадикс хуулийн фирмтэй хамтран хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчны судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны үр дүн болон холбогдох талуудын оролцоотой хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтэд тулгуурлан хөрөнгө оруулалтын сан, ялангуяа гэрээний сантай холбоотой татварын бодлого, КҮС/AML шаардлагын хэрэгжилтэд үүсэж буй эрх зүйн тодорхойгүй байдлыг арилгах зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Монгол Банк болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг эхлүүлээд байна. Уг ажлын хүрээнд татварын ил тод байдал, КҮС/AML-ийн зохицуулалтын зөрчил, давхардал, гэрээний сангийн үүсгэн байгуулалтын эрх зүйн зохицуулалт, татварын нэг мөр ойлголтыг тодорхойлох чиглэлээр санал, тайлбар боловсруулж байгаа бөгөөд энэхүү ажлыг 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.



2.1.3. Зохицуулалт орчин, зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр оролцсон ажлын хэсгүүд

АЖЛЫН ХЭСГҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОО

Холбооноос байгуулагдсан дараах ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд тус тус оролцон, холбогдох асуудлуудыг хэлэлцэж, санал дүгнэлт боловсруулан ажилласан.



Үүнд: хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогоос албан татвар суутгаж буй асуудлыг шийдвэрлэх, үнэт цаасны компаниудын харилцагчдыг шилжүүлэх уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн Монгол Улсын хөрөнгийн зах зээлд оролцоог нэмэгдүүлэх хүрээнд үнэт цаасны данс нээх үйл ажиллагааг хялбаршуулах, мөн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд таниулах, санхүүгийн мэдлэг олгох, зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллага болон салбарын зохицуулалтын байгууллагуудтай хамтран ажиллах асуудлууд багтсан.

Түүнчлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлийн үнэлгээ хийх, тайлагнах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулсан байна.

2.1.4. Хамтын ажиллагаа

УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ



2025 оны 9 дүгээр сард Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо Азийн Үнэт Цаасны Форумын (Asia Securities Forum, ASF) 30 дахь удаагийн Жилийн Ерөнхий Хурал амжилттай зохион байгуулагдаж, тус арга хэмжээний хүрээнд “Улаанбаатарын тунхаглал”-ыг албан ёсоор баталж, гарын үсэг зурах ёслол боллоо.

Энэхүү арга хэмжээ нь ASF байгуулагдсаны 30 жилийн ойтой давхцан зохион байгуулагдсан бөгөөд Ази, Номхон далайн бүс нутгийн капитал зах зээлийн хамтын ажиллагааны өнгөрсөн 30 жилийн ололт амжилтыг дүгнэхийн зэрэгцээ ирэх 30 жилийн хамтын алсын хараа, стратегийн чиглэлийг тодорхойлсон түүхэн ач холбогдолтой байв.

“Улаанбаатарын тунхаглал”-аар ASF-ийн гишүүд дараах дөрвөн үндсэн чиглэлд хамтран ажиллахаа илэрхийлэв. Үүнд:

- Дижитал шилжилтийг эрчимжүүлж, аюулгүй, хүртээмжтэй, уялдаа холбоотой дижитал капитал зах зээлийн дэд бүтцийг бүс нутагт хөгжүүлэх;
- Тогтвортой санхүүжилтийг дэмжиж, тогтвортой нийгэм-эдийн засгийн хөгжил болон хүртээмжтэй өсөлтийг хангах;
- Хөрөнгө оруулагчдыг чадавхжуулж, санхүүгийн боловсрол болон хөрөнгө оруулагчийн хамгаалалтыг сайжруулах;
- Бүс нутгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, ASF-ийн хүрээнд харилцан ойлголцол, хамтарсан санаачилга, үр дүнтэй яриа хэлэлцээг бэхжүүлэх.

Тунхаглалд гарын үсэг зурснаар ASF-ийн гишүүд тэсвэртэй, хүртээмжтэй, тогтвортой, ирээдүйд бэлэн капитал зах зээлийг хамтран хөгжүүлэх нийтлэг зорилгодоо үнэнч байгаагаа баталгаажуулж, бүс нутгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах бодит суурийг тавилаа.

2.1.4. Хамтын ажиллагаа

БОНД ФОРУМ 2025



“Бонд Форум 2025” арга хэмжээний хүрээнд Монгол Улсын томоохон аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд татан оролцуулах, ялангуяа Топ-100 аж ахуйн нэгжийг нийтэд санал болгон үнэт цаас (бонд, IPO) гаргахад бодлогын болон институцийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Уг санамж бичигт Санхүүгийн зохицуулах хорооны Дарга Т.Жамбаажамц, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгч Л.Төр-Од, Монголын Хөрөнгийн Биржийн Гүйцэтгэх захирал Б.Дөлгөөн, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн дарга Г.Энхбат нар гарын үсэг зурсан.

Энэхүү хамтын ажиллагаа нь банк төвтэй санхүүжилтийн бүтцийг төрөлжүүлэх, бодит секторын компаниудыг урт хугацааны зах зээлийн санхүүжилтэд шат дараатайгаар холбох, бондын зах зээлийн идэвх, гүнзгийрлийг нэмэгдүүлэх стратегийн зорилготой. Санамж бичгийн хүрээнд талууд Топ-100 аж ахуйн нэгжүүдэд үнэт цаас гаргахтай холбоотой зохицуулалт, зардлын хөнгөлөлт, мэргэжлийн зөвлөгөө, сургалт, мэдээллийн дэмжлэг үзүүлэх, мөн зах зээлийн орчныг сайжруулах бодлогын түвшний хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр тохиролцсон.

Энэхүү санаачилга нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг бодит эдийн засагтай илүү нягт уялдуулах, компаниудын ил тод байдал, засаглалыг сайжруулах, дотоодын бондын зах зээлийг тогтвортой хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

2.1.4. Хамтын ажиллагаа

WEFINANCE CODE

2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр Монгол Улсын Төрийн ордны Их танхимд Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүжилтийн код (WeFinance Code)-ын нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн дарга Г.Энхбат оролцож, эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой “Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код”-д нэгдэж буйгаа илэрхийлэн амлалтын бичигт гарын үсэг зурлаа.



2024 оны байдлаар WeFinance Code-д эдийн засаг, санхүүгийн орчны хувьд Монгол Улстай төстэй 24 хөгжиж буй улс орон нэгдээд байна. Монгол Улсад эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн оролцоо өндөр боловч бизнесийн санхүүжилтийн хүртээмж хязгаарлагдмал хэвээр байгаа бөгөөд Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн 60 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ч санхүүжилт авах боломж харьцангуй доогуур байна.


WeFinance Code-д нэгдсэнээр жендерт суурилсан өгөгдлийн тогтолцоо бүрдэх, олон улсын аргачлалыг нутагшуулах, хөгжлийн банкнуудаас санхүү, техник туслалцаа авах, бүс нутгийн хамтын ажиллагааг манлайлах, туршлага түгээх бодит боломжтой болж байна.



2.1.4. Хамтын ажиллагаа

МОНГОЛЫН НОТАРИАТЧДЫН ТАНХИМ, МҮЦАЭХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

2025 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Монголын Нотариатчидын Танхим болон Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Санамж бичигт Монголын Нотариатчидын Танхимыг төлөөлж Ерөнхийлөгч Ч.Баянжаргал, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоог төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Буянхишиг нар гарын үсэг зурлаа.



Энэхүү санамж бичгийн хүрээнд талууд сайн туршлага нэвтрүүлэх зорилгоор уулзалт, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах, мөн биржийн бус зах зээлд нотариатын мэдэгдэх хуудсыг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцоод байна.

2.1.4. Хамтын ажиллагаа

БИЗНЕСИЙН ХОЛБООД НЭГДСЭН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХААР ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг төлөөлсөн бизнесийн голлох холбоод нэгдсэн мэргэжлийн зөвлөл байгуулах зорилгоор хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

Энэхүү санамж бичиг нь бизнесийн салбарын нийтлэг эрх ашгийг хамгаалах, хувийн хэвшлийн нэгдсэн дуу хоолойг бүрдүүлэх, бизнесийн эрх зүйн орчныг сайжруулах, салбар хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлэх, мөн гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих тогтвортой хамтын ажиллагааны платформ байгуулах суурийг тавьж байна.

Санамж бичигт дараах байгууллагууд нэгдэв. Үүнд:

- Монголын уул уурхайн үндэсний ассоциаци
- Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо
- Монголын Даатгалын Зах Зээлийн Холбоо (MIMA)
- Монголын газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдын мэргэжлийн холбоо
- Газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлогчдын холбоо

Санамж бичгийн хүрээнд талууд нэгдсэн мэргэжлийн зөвлөлийн бүтэц, зохион байгуулалтыг боловсруулах, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах, хууль эрх зүйн орчныг сайжруулахад бодитой хувь нэмэр оруулах, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилт тавин хамтран ажиллахаар тохиролцлоо.

2.1.4. Хамтын ажиллагаа

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО АЙ ТИ ИНСАЙТ ХХК-ТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо нь мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Ай Ти Инсайт ХХК-тай 2025 оны 5 дугаар сарын 19-ний өдөр хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа.

Санамж бичгийн хүрээнд Ай Ти Инсайт ХХК нь Холбооны мэдээллийн систем, дэд бүтцийг хөгжүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, хөрөнгийн зах зээлийн цахим шилжилтийг дэмжих, өгөгдлийн стандарт боловсруулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон. Мөн Холбооны гишүүн байгууллагуудад 10–20 хувийн хөнгөлөлттэй мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэхээр боллоо.

Ай Ти Инсайт ХХК нь мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ, төслийн менежмент, ажиллах хүчний сургалт, тоног төхөөрөмжийн хангамж зэрэг чиглэлээр олон жилийн туршлагатай, салбартаа танигдсан компани юм ын ажиллагааг өргөжүүлэх зорилт тавин хамтран ажиллахаар тохиролцлоо.

2.1.4. Хамтын ажиллагаа

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо нь хөрөнгийн зах зээлийн мэдлэг, боловсролыг олон нийтэд түгээх ажлын хүрээнд Монголын Хөрөнгийн Биржтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Энэхүү хамтын ажиллагааны үр дүнд “Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт” цахим хэлбэрт шилжиж, сонирхсон иргэн бүр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран 11 цуврал хичээлийг онлайнаар үзэх боломжтой боллоо.

Тус цахим сургалт нь Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо e.masd.mn платформ дээр нээлттэй байрших бөгөөд ингэснээр хөрөнгийн зах зээлийн суурь мэдлэгийг олон нийтэд өргөн хүрээтэй, тасралтгүй түгээх шинэ боломж бүрдэж байна.

A large, high-contrast, black and white photograph of a faceted diamond. The diamond is the central focus, with its numerous facets catching the light and creating a complex pattern of highlights and shadows. The background is dark, making the diamond stand out prominently.

2.2. Дэд бүтэц, цахимжуулалт

2.2.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн үйл ажиллагааны цахимжуулалт

20 Сая Төгрөгөөс Дээш Гүйлгээг Хянах, Зохицуулах Цахим Систем

Гишүүн байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн 20 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээтэй холбоотой зохицуулалтад өөрчлөлт орууллаа.

Өмнөх зохицуулалтаар 20 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв гүйцэтгэхийн тулд заавал цаасан хэлбэрийн “мөнгө хүсэх баримт” бүрдүүлэн ирүүлэх шаардлагатай байсан.



Харин шинэчилсэн зохицуулалтаар гурвалсан гэрээ байгуулсан харилцагчийн 20 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээг цахимаар гүйцэтгэх боломж бүрдсэнээр үйл ажиллагааны хугацаа, зардлыг бууруулж, гүйлгээний үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэв.

2.2.2. ISIN дугаар

ISIN ДУГААР ОЛГОЛТЫН ЦАХИМЖИЛТ

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн хооронд байгуулсан 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн ХАГ/2025/01 тоот гэрээний хүрээнд биржийн бус зах зээлд арилжаалах үнэт цаасны нэгдсэн дугаар (ISIN) олгох процессыг цахим хэлбэрт шилжүүлж, арилжааны системээр дамжуулан авдаг боллоо. Үүний үр дүнд гар ажиллагаа, цаасан баримтад тулгуурлаж байсан процесс богиносж, ISIN дугаар хүлээдэг байсан хугацаа багасаж санхүүжилт татах, арилжаа эхлэх хурдассанаар зах зээлийн идэвх нэмэгдэх юм. Уг гэрээ нь биржийн бус зах зээлийн үнэт цаасыг төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэх, хадгалах, өмчлөл шилжүүлэх, төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

2.2.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн системийн шаардлагын төсөл

ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛИЙН САНАЛЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ЯВЦ

Монгол улсын засгийн газрын 2024–2028 оны мөрийн хөтөлбөрийн 3.1.3.9 дэх зорилт болох “хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын системийн цогц шинэчлэлийг хэрэгжүүлж, олон улсын стандарт бүхий нэгдсэн шийдлийг зах зээлд нэвтрүүлэх” зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо гишүүн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Ажлын хэсэг нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн системийн шаардлагад хөрвүүлэх саналын төслийг боловсруулах, мөн хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн оролцогчдын систем хоорондын мэдээллийн урсгалыг стандартчилах асуудлыг хэлэлцлээ.

Энэхүү ажил нь зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын системийн уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн найдвартай байдал, үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад олон улсын стандарттай нийцсэн нэгдсэн дэд бүтцийн суурь бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

2.2.2. Гишүүдийн хувьцаа ЭЗЭМШИГЧДИЙН ЗАР

ТӨЛБӨРТЭЙ ЗАРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь 2025 оны хугацаанд гишүүн компаниудын хүсэлтийн дагуу нийт 71 удаагийн төлбөртэй зар (хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой заруудыг оролцуулан) амжилттайгаар нийтэлж, олон нийтэд түгээсэн байна.

Энэхүү үйлчилгээ нь гишүүн байгууллагуудын хууль, зохицуулалтын дагуу мэдээллийг цаг тухайд нь, ил тод хүргэх нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгө оруулагчидтай харилцах харилцааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

Түүнчлэн уг үйлчилгээ нь зах зээлийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн ил тод, шударга орчныг бүрдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан юм.

2.2.3. Бодлогын шинэчлэл санаачилга

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЦИЙГ ШИНЭЧЛЭХ БОДЛОГО, ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь 2024 оны Улсын их хурлын сонгуульд өрсөлдсөн шилдэг гурван намд хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг олон улсын түвшинд хүргэх бодлогын саналыг албан ёсоор хүргүүлсэн бөгөөд уг санал нь засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан. Үүний үндсэн дээр засгийн газрын дэргэд холбогдох ажлын хэсэг байгуулагдаж, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоог төлөөлөн гүйцэтгэх захирал Б.Буянхишиг тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.

Ажлын хэсгийн дүгнэлтээр хөрөнгийн зах зээлийг богино хугацаанд шинэчлэх, олон улсын стандарттай нийцүүлэх анхны бөгөөд суурь алхам нь зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын системийн шинэчлэл гэж үзсэн. Үүний хүрээнд:

- Зах зээлийн системийн гурван үндсэн байгууллага болох бирж, төвлөрсөн хадгаламж, клирингийн системийг шинэчлэх,
- Клирингийн үйл ажиллагааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй нэгтгэх шийдвэрүүдийг гаргасан.

Мөн системийн шинэчлэлтэй холбоотой тендерийн ажиллагаа эхэлж, системийн даалгаврын төсөлд Холбооноос санал өгсөн бөгөөд уг тендерийн үйл явц 2026 он хүртэл үргэлжлэхээр төлөвлөгдсөн байна.

Үүнтэй зэрэгцэн монголын хөрөнгийн бирж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь гишүүн байгууллагуудаас дэд бүтцийн өөрчлөлттэй холбоотой санал, байр суурийг авч нэгтгэсэн. Гишүүдийн саналаар:

- Бирж болон дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулах,
- Системийн худалдан авалтыг олон улсын түвшинд, ил тод, найдвартай байдлаар зохион байгуулах шаардлагатай гэсэн байр суурь давамгайлсан байна.

Эдгээр санал, дүгнэлт нь хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийг зах зээлийн оролцогчдын эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэх, урт хугацаанд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

2.3. Гадаад дотоод арга хэмжээ

2.3.1. 30th ASF Annual General Meeting

АЗИЙН ҮНЭТ ЦААСНЫ ФОРУМ



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь Ази-Номхон далайн бүсийн үнэт цаасны салбарын нэр хүндтэй олон улсын чуулган болох Азийн Үнэт Цаасны Форум (ASF)-ын түүхт 30 дахь удаагийн Ерөнхий Чуулганыг 2025 оны 9 дүгээр сарын 10–13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо анх удаа амжилттай зохион байгууллаа. Уг чуулган нь өмнө нь Токио, Хонконг, Сөүл, Сингапур зэрэг Азийн тэргүүлэх санхүүгийн төвүүдэд зохиогдож ирсэн бөгөөд бүс нутгийн 23 улс орны үнэт цаасны салбарын холбоод, зохицуулах байгууллагууд, зах зээлийн гол оролцогчдыг нэгтгэдэг чухал олон улсын индэр юм.

ASF 2025 чуулганы хүрээнд 2025 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр “Mongolian Capital Market Connectivity 2025 (MCMC 2025)” тусгай арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээ нь Монголын үнэт цаас гаргагч компаниудад Ази болон олон улсын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагуудтай шууд холбогдох, өөрсдийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын боломжийг танилцуулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх бодит боломжийг олгосон онцлогтой байв.

MCMC 2025 арга хэмжээ нь:

- Монголын хөрөнгийн зах зээлийн олон улсын нэр хүндийг нэмэгдүүлэх,
- Монголын компаниудын гадаад зах зээлд нэвтрэх боломжийг тэлэх,
- гадаадын хөрөнгө оруулалт, санхүүжилт татах орчныг сайжруулах,
- төр-хувийн хэвшлийн үр ашигтай түншлэлийг дэмжих

чиглэлд чухал ач холбогдол бүхий арга хэмжээ болж, Монголын хөрөнгийн зах зээлийг бүс нутгийн болон олон улсын түвшинд идэвхтэй холбох стратегийн зорилтыг бодитоор хэрэгжүүлсэн юм.

2.3.2. Grand Bull Awards

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ШИЛДГҮҮДИЙГ АЛДАРШУУЛАХ ОЙН АРГА ХЭМЖЭЭ



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан хөрөнгийн зах зээлийн хөгжилд бодит хувь нэмэр оруулсан шилдэг мэргэжилтэн, байгууллага, төсөл, санаачилгыг үнэлж алдаршуулах зорилгоор шагнал гардуулах ёслолын арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээ нь Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос дөрөв дэх удаагаа зохион байгуулж буй салбарын нэр хүндтэй арга хэмжээ юм.

Тус арга хэмжээ нь капитал зах зээлийн ёс зүй, мэргэжлийн ур чадвар, манлайлал, инновацыг олон нийтэд таниулах, салбарын шилдэг туршлагыг сурталчлах, улмаар хөрөнгийн зах зээлийн нэр хүнд, итгэлцлийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан онцгой үйл явдал боллоо.

Арга хэмжээний хүрээнд капитал зах зээлийн мэргэжлийн хүний нөөц, байгууллагын манлайлал, шинэ бүтээгдэхүүн, төсөл, санаачилгыг цогцоор нь үнэлж, тогтвортой санхүүжилт, ногоон бонд, хүртээмжтэй боловсрол, ил тод харилцааг дэмжсэн санаачилгуудыг онцлон тодотгосон. Мөн банк, үнэт цаасны компани, хөрөнгө оруулалтын менежмент, зах зээлийн дэд бүтэц, бодит эдийн засгийн төслүүдийг хамарсан өргөн хүрээтэй оролцоотой арга хэмжээ болж зохион байгуулагдсан.

2.3.2. Олон улсын хамтын ажиллагаа

MONGOLIA INVESTMENT FORUM – ЛОНДОН, ИХ БРИТАНИ



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Лондон хотноо зохион байгуулагдсан Mongolia Investment Forum-д оролцож, Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгө оруулагчид, лондонгийн хөрөнгийн бирж болон санхүүгийн байгууллагуудад сурталчлах, холбооны үйл ажиллагаа, стратегийн зорилтыг танилцуулах, цаашдын хамтын ажиллагааны боломжийг эрэлхийлэв.



Форумын хүрээнд Лондонгийн Хөрөнгийн Бирж болон олон улсын санхүүгийн байгууллагуудын удирдлага, төлөөлөлтэй уулзалт хийж, монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоог монгол улсын хөрөнгийн зах зээлийн төсөл, санаачилгыг хэрэгжүүлэх итгэлтэй түнш байгууллага болохыг онцлон танилцуулсан. Мөн монголын хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүд, ялангуяа залуу боловсон хүчний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, олон улсын сургалт, хөтөлбөрт хамруулах шаардлагыг тодотгож, мэргэжлийн чадавхыг тасралтгүй хөгжүүлэхийн ач холбогдлыг хөндсөн.

2.3.2. Олон улсын хамтын ажиллагаа

ICMA-ТАЙ УУЛЗАЛТ (ЛОНДОН)

Форумын дараа Олон Улсын Хөрөнгийн Зах Зээлийн Холбоо (ICMA)-ийн Тогтвортой хөгжил, Боловсрол, Гишүүнчлэл хариуцсан хэлтсийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, хамтын ажиллагаанд талархал илэрхийлэн цаашдын хамтын ажиллагааны чиглэлүүдийг хэлэлцэв. Уулзалтын үеэр дэлхийн хөрөнгийн зах зээлийн шинэ чиг хандлага, тогтвортой санхүүжилтийн санаачилгууд, Монголын мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, мэргэшлийн хөтөлбөр хэрэгжүүлэх боломжуудыг судалсан. Энэхүү айлчлал нь монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны олон улсын нэр хүндийг бэхжүүлж, стратегийн түншлэлийг өргөжүүлэх бодит үр дүнтэй боллоо.



СИНГАПУРЫН ҮНЭТ ЦААСНЫ ХОЛБООТОЙ УУЛЗАЛТ

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Сингапурын Үнэт Цаасны Холбоотой уулзалт зохион байгуулж, Монгол–Сингапурын 50 гаруй жилийн найрсаг харилцаанд тулгуурлан ASF-ын хүрээнд хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэдлэг, туршлага солилцох, цаашдын хамтын санаачилгуудыг судлах талаар санал солилцов. Мөн ASF-ын 30 дугаар чуулганд идэвхтэй оролцсонд талархал илэрхийлж, ирээдүйд илүү үр өгөөжтэй хамтын ажиллагааг хөгжүүлэхээр тохиролцов.

2.3.2. Олон улсын хамтын ажиллагаа

ТОГТВОРТОЙ БОНДЫН ЗАРЧМУУДЫН 11 ДЭХ УДААГИЙН ЖИЛИЙН БАГА ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр Токио хотноо зохион байгуулагдсан Ногоон, Нийгмийн, Тогтвортой болон Тогтвортой байдалтай уялдсан бондын зарчмууд (GSSS Bond Principles)-ын 11 дэх удаагийн жилийн бага хуралд монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны төлөөлөгч оролцов. Уг хурал нь тогтвортой бондын зах зээлийн дэлхийн хэмжээний тэргүүлэх арга хэмжээ бөгөөд зохицуулагч байгууллагууд, үнэт цаас гаргагчид, банкнууд, хөрөнгийн удирдлагын компаниуд өргөнөөр оролцсон.

Хурлаар тогтвортой болон шилжилтийн санхүүжилтийн зах зээлийн сүүлийн үеийн хөгжил, бондын зарчмуудын шинэчилсэн удирдамж, зохицуулалтын орчны өөрчлөлт, зах зээлд үзүүлэх нөлөөг хэлэлцэв. Энэхүү арга хэмжээнээс олж авсан мэдлэг, олон улсын шилдэг туршлага нь Монголын хөрөнгийн зах зээлд тогтвортой болон шилжилтийн санхүүжилтийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган улирал тутам сургалт, сурталчилгаа зохион байгуулахаар бэлтгэж байна.



МОНГОЛ-ЯПОНЫ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН XII ЗӨВЛӨЛДӨХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан Монгол-Японы төр, хувийн хэвшлийн түншлэлийн XII зөвлөлдөх хуралд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга Г.Энхбат оролцож, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, биржийн бус зах зээлийн хөгжил, Япон улсын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах боломжийн талаар албан илтгэл танилцууллаа.

2.3.3. Summer festival

ЗУНЫ АРГА ХЭМЖЭЭ

2025 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Гачууртын Шар хоолойн аманд байрлах “Gobi Deluxe Resort”-д салбарын байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Summer Festival арга хэмжээг Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК, Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв ХХК, Монголын Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-ийн төлөөлөлтэй хамтран зохион байгууллаа.



Арга хэмжээнд 20 гаруй гишүүн компанийн 250 орчим ажилтан оролцож, байгууллагууд хоорондын уялдаа холбоог сайжруулах, оролцогчдын идэвхтэй оролцоог хангах, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд 3х3 сагсан бөмбөг, гар бөмбөг, хөгжимт бясалгал, иог, арт канвас, морин аялал зэрэг хөтөлбөрүүд багтсан бөгөөд морин аялалд 60, арт канваст 60, иогт 16, хөгжимт бясалгалд 33 ажилтан тус тус хамрагдсан бол бусад оролцогчид спортын төрлүүдийг сонгон оролцсон байна.

Мөн арга хэмжээний хүрээнд оролцогчдын багаар ажиллах чадвар, идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Quiz Night танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж, соёл, урлагийн хөтөлбөрийн хүрээнд Opozit, Tatar хамтлаг болон уран бүтээлчдийг урьж оролцуулснаар оролцогчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн.

Тус арга хэмжээ нь салбарын байгууллагуудын ажилтнуудын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, ажлын ачааллыг бууруулах, багийн ажиллагааг сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо.

2.3.4. Зах зээлийн 5 төрөлт спортын тэмцээн

“СПОРТЫН ИХ НААДАМ 2025” АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монголын хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын дунд уламжлал болгон зохион байгуулагдаж ирсэн “Спортын их наадам 2025” арга хэмжээг Монголын Хөрөнгийн Бирж 2025 оны 1 дүгээр сарын 11-ээс 1 дүгээр сарын 18-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд Холбоо нь ерөнхий зохион байгуулагчаар хамтран оролцож, Монголын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн байгууллагуудад ажиллаж буй мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортын талбарт шударгаар өрсөлдөх, салбарын спортын шилдгүүдийг алдаршуулах зорилгод бодит хувь нэмэр оруулан ажилласан.

“Спортын их наадам 2025” нь салбарын байгууллагуудын ажилтнуудын харилцаа, багийн ажиллагааг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих, эерэг уур амьсгалыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой уламжлалт арга хэмжээ боллоо.

2.3.5. Хөрөнгө оруулагчдын өдөр

“ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ӨДӨР” НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ

2025 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Монголын Хөрөнгийн Бирж ХК-аас “Хөрөнгө оруулагчдын өдөр” нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, 500 орчим иргэн, хөрөнгө оруулагчид үнэт цаасны зах зээлийн талаарх мэдээлэл хүргэлээ.

Өдөрлөгт Санхүүгийн зохицуулах хороо, зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо болон үнэт цаасны компаниуд оролцож, иргэдэд хөрөнгө оруулалтын боломж, мэргэжлийн үйлчилгээний талаар цогц мэдээлэл, зөвлөгөө өгсөн ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

2.3.6. Тэрбум мод

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРИХ АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 44 дүгээр зарлигаар баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо болон гишүүн байгууллагууд хамтран 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд намрын мод тарих арга хэмжээг зохион байгууллаа.

Тус арга хэмжээ нь Туул голын ундны усны эх үүсвэрийг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэвэр агаар, эрүүл экосистемийг бүрдүүлэхэд чиглэсэн бөгөөд Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан чухал үйл ажиллагаа болов.

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо нь уг үндэсний хөдөлгөөнд идэвхтэй оролцож, байгаль орчны тэнцвэрийг хадгалах, тогтвортой хөгжлийг дэмжих, ирээдүй хойч үедээ эрүүл, ногоон орчныг өвлүүлэн үлдээхэд бодит хувь нэмэр орууллаа.



2.3.7. Хөрөнгийн зах зээл ба 1072 хувьцаа

“ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА 1072 ХУВЬЦАА” БАРУУН БҮСИЙН ӨДӨРЛӨГ

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо (МҮЦАЭХ) нь Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж, ҮЦТХТ ХХК-тай хамтран 2025 оны 9 дүгээр сарын 22–26-ны өдрүүдэд Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгуудад “Хөрөнгийн зах зээл ба 1072 хувьцаа” өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.



Тус өдөрлөгт баруун бүсийн 1000 гаруй иргэн оролцож, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын боломж, 1072 хувьцаатай холбоотой хамгийн сүүлийн үеийн бодит мэдээллийг мэргэжлийн байгууллагуудаас шууд авах боломж бүрдсэн нь олон нийтийн санхүүгийн боловсрол, зах зээлийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

2.3.8. Цан цохих ёслол

ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА ЭХЭЛСНИЙ 30 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсний 30 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн цан цохих ёслол өнөөдөр зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээ нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түүхэн замнал, ололт амжилтыг тэмдэглэн дурсах, салбарын үе үеийн оролцогчдын хувь нэмрийг үнэлэх зорилготой байв.



Ёслолын ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн дарга Г.Энхбат, мөн Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ХК, Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв ХХК, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв, МҮЦАЭХ-ийн Ахмадын зөвлөл, түүнчлэн 30 жилийн өмнө зах зээлийн арилжаанд оролцож байсан анхны 29 брокерын төлөөлөл оролцлоо.

Энэхүү ой нь Монголын үнэт цаасны зах зээл тогтвортой хөгжиж ирснийг илэрхийлэхийн зэрэгцээ салбарын институцийн хөгжил, мэргэжлийн хүний нөөцийн залгамж чанарыг онцолсон ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

2.3.9. Санхүүгийн зах зээл ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

“САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ” АРГА ХЭМЖЭЭ

Монголын Хөрөнгийн Бирж болон Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль хамтран зохион байгуулсан “Санхүүгийн зах зээл ба тогтвортой хөгжил” арга хэмжээнд Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн дарга Г.Энхбат оролцлоо.

Арга хэмжээний хүрээнд сүүлийн жилүүдэд Монголын хөрөнгийн зах зээлд гарсан өсөлт, ололт амжилт, өнөөгийн тулгамдсан асуудлууд, цаашдын хөгжлийг хангахад бодлого тодорхойлогчдоос авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар оролцогчдод мэдээлэл өгсөн. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан “Зээлийн хүү бууруулах үндэсний стратеги” хэрэгжээгүй шалтгааны талаар өөрийн байр суурийг илэрхийллээ.




2.3.10. Орон нутагт ЭТТ хувьцааны талаар мэдээлэл олгох сургалт

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА БОЛОН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ИРГЭДЭД ХҮРГЭЛЛЭЭ

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, иргэдийн санхүүгийн боловсрол, хувьцаа болон хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 6 дугаар сарын 23–24-ний өдрүүдэд Дундговь, Өмнөговь аймагт сургалт, сурталчилгааны нэгдсэн өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК, үнэт цаасны компаниуд, МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниуд оролцож, орон нутгийн иргэдэд хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээлийн талаарх мэдээлэл хүргэхийн зэрэгцээ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшил, зах зээлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар танилцуулж, хөрөнгө оруулагчдыг бэлтгэх, үнэт цаас гаргагчдад зөвлөмж өгч ажиллав.

Энэхүү өдөрлөг нь иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг сурталчлах, нэг цэгээс мэдээлэл, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

A large, high-contrast, black and white photograph of a faceted diamond, showing its intricate facets and light reflections. The diamond is the central focus of the page.

2.4. Зах зээлийн мэргэжилтнүүдийг хөгжүүлэх

2.4.1. ICMA 2025 ОНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

ICMA ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ МОНГОЛЫН МЭРГЭЖИЛТЭН ШАЛГАРЛАА



International
Capital
Market
Association

“ICMA Scholarship Programme 2025” тэтгэлэгт хөтөлбөрт Монгол Улсаас “Голомт Капитал ҮЦК”-ийн Эрсдэлийн ахлах шинжээч Ё.Нямдулам шалгарсан байна. Тус хөтөлбөрт энэ жил түүхэн дэх хамгийн олон өргөдөл ирсэн бөгөөд оролцогчдыг мэргэжлийн туршлага, академик амжилт, суралцах хүсэл эрмэлзэл, хувийн мэдэгдэлд тусгасан зорилго, тэмүүллийг нь үндэслэн Ази, Африк, Латин Америкийн бүс нутгаас нийт 15 мэргэжилтнийг сонгон шалгаруулжээ.

ICMA-ийн тэтгэлэгт хөтөлбөр нь дэлхийн хөрөнгийн зах зээлд стандарт, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд шалгарсан оролцогчид нэг жилийн хугацаанд цахим сургалтад хамрагдаж дараах хөтөлбөрүүдээс сонгон суралцах боломжтой. Үүнд:

- ICMA Diploma in Debt Capital Markets
- ICMA Diploma in Securities & Derivatives
- ICMA Diploma in Financial Market Operations

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо нь 2021 оны 7 дугаар сараас ICMA (International Capital Market Association)-тай харилцан гишүүнчлэлтэй ажиллаж байгаа бөгөөд ICMA нь дэлхийн 620 гаруй гишүүнтэй, бондын зах зээлээр мэргэшсэн, олон улсын нэр хүндтэй байгууллага юм. Энэхүү амжилт нь Монголын хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн боловсон хүчний чадавх олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөж буйг илэрхийлсэн чухал үр дүн боллоо.

2.4.2. JOB FAIR

ЗАЛУУ МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОРИУЛСАН JOB FAIR ӨДӨРЛӨГТ ОРОЛЦЛОО

Санхүүгийн зохицуулах хороо, МУИС, СЭЗИС, Сити дээд сургуулиудтай хамтран залуу мэргэжилтнүүдэд зөвлөгөө, мэдээлэл хүргэх зорилготой JOB FAIR өдөрлөгийг зохион байгуулахад Холбоо гишүүн байгууллагуудаа оролцуулан хамтран ажиллалаа.

2025 оны 4 дүгээр сарын 23, 24, 29-ний өдрүүдэд үргэлжилсэн уг өдөрлөгт Холбооны гишүүн байгууллагуудаас Бидисек ҮЦК ХХК, Үнэт Санхүүгийн Нэгдэл, Стокларб ҮЦК ХХК, Голомт Капитал ҮЦК ХХК оролцож, оюутан, залуу мэргэжилтнүүдэд хөрөнгийн зах зээлийн чиглэлээр ажлын байр, мэргэжлийн чиг баримжаа, карьер хөгжлийн талаарх мэдээлэл, зөвлөгөөг хүргэлээ.

2.4.3. Зах зээлийн чимээ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БОДЛОГЫН НЭВТРҮҮЛЭГ “ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИМЭЭ”

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо, Capital Markets Mongolia, Монгол ТВ хамтран хөрөнгийн зах зээлийн тулгамдсан болон чухал асуудлуудыг олон нийтэд бодлогын түвшинд хүргэх зорилгоор “Зах зээлийн чимээ” нэвтрүүлгийг хэрэгжүүлж, өнөөдрийн байдлаар хөрөнгийн зах зээлийн 10 чухал сэдвийг хамарсан 10 дугаарыг амжилттай бэлтгэн олон нийтэд цацсан байна.



Тус нэвтрүүлгийг бодлогын хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулж, Монгол ТВ болон YouTube сувгаар олон нийтэд хүргэсэн бөгөөд иргэдийн санхүүгийн боловсрол, зах зээлийн оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн.

2.4.4. Өглөөний уулзалт

МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

“Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн онцлох сэдвүүд” өглөөний уулзалт

2025 оны 8 дугаар сарын 28-ны өдөр уг сэдвээр өглөөний уулзалт зохион байгуулж, зочин илтгэгчээр Ү.Амарбат (УИХ-ын Тамгын газрын дэд дарга, хууль зүйн доктор), Ө.Эрдэнэ-Очир (Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-ийн партнер, гүйцэтгэх захирал, хууль зүйн магистр) нар оролцон хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлын талаар гишүүдтэй хэлэлцүүлэг өрнүүлэв.

Эмэгтэй мэргэжилтнүүдийн уулзалт

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан эмэгтэй мэргэжилтнүүдийн уулзалтыг зохион байгуулж, урилгаар “Өлзий энд Ко Капитал ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр оролцон өөрийн туршлага, мэргэжлийн өсөлтийн талаар чөлөөт ярилцлага хийв.

Мэдээллийн технологийн ажилтнуудын уулзалт

2025 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр мэдээллийн технологийн ажилтнуудын уулзалтыг зохион байгуулж, зах зээлийн оролцогчид болон дэд бүтцийн байгууллагуудын хоорондох цахим мэдээлэл солилцох (API) шийдэл, дэд бүтцийн цахим үйлчилгээ, тулгамдсан асуудал, шийдвэрлэх саналуудыг хэлэлцэв. Гарсан саналуудыг Сангийн сайдын байгуулсан холбогдох ажлын хэсэг болон дэд бүтцийн байгууллагуудын удирдлагуудад хүргэхээр ажиллаж байна.

ХОМК-уудын эрх зүйн, татварын орчны уулзалт

2025 оны 12 дугаар сарын 4-ний өдөр гишүүн ХОМК-уудтай уулзалт зохион байгуулж, “Номадикс” хуулийн фирмтэй хамтран хийсэн эрх зүйн орчны судалгааны үр дүн, сайжруулах боломж, санал дүгнэлтийг танилцуулан хэлэлцүүлэг өрнүүлэв.

Эдгээр уулзалт, хэлэлцүүлгүүд нь зах зээлийн оролцогчдын мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх, бодлого, зохицуулалтын асуудлаар нэгдсэн ойлголт бүрдүүлэх, салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

2.4.5. Вебинар сургалт

МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН ВЕБИНАР СУРГАЛТ

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо (МҮЦАЭХ) нь олон улсын нэр хүндтэй байгууллага, их сургууль, мэргэжлийн холбоодтой хамтран “Capital Markets: Digital Transformation and Sustainable Development” сэдэвт вебинарын цувралыг хэрэгжүүлж, нийт 8 удаагийн вебинарыг амжилттай зохион байгууллаа.

Вебинарын цуврал нь дараах үндсэн сэдвийн хүрээг хамарсан. Үүнд:

- Хөрөнгийн зах зээлийн дижитал шилжилт, RegTech
- Санхүүгийн зөвлөх үйлчилгээний зах зээлийн бүтэц, зохицуулалтын шинэчлэл
- Тогтвортой болон ногоон санхүүжилт, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хөрөнгө оруулалт
- Ногоон төслийн pipeline хөгжүүлэлт, санхүүжилт татах аргачлал
- REITs болон хөрөнгийн зах зээлийн шинэ бүтээгдэхүүн
- Биет бус хөрөнгийн үнэ цэнэ, технологи, инновацийн нөлөө
- Ази, Номхон далайн бүсийн тогтвортой санхүүгийн зах зээлийн чиг хандлага

Вебинаруудад дараах олон улсын байгууллага, их сургуулийн нэр хүндтэй зочин илтгэгчид оролцов. Үүнд:

- UN ESCAP / Climate Invest Project – Deanna Morris, Chiara Amato
- DeVry University, TechFides (АНУ) – Dr. Claude Oakley, Dr. Kasthuri Henry
- CFA Institute, Janney Montgomery Scott (АНУ) – Mr. Steve Dumanski, CFA
- INSEAD Business School – Ben Charoenwong, Санхүүгийн тэнхимийн дэд профессор
- Олон Улсын Капитал Зах Зээлийн Холбоо (ICMA) – Муштак Капаси, Ази–Номхон далайн бүсийн захирал
- Хонг Конгийн Их Сургууль – Доктор Алан П. Куан, Санхүүгийн тэнхимийн дэд профессор

Эдгээр 8 удаагийн вебинар нь Монголын хөрөнгийн зах зээлд олон улсын шилдэг туршлага, бодлогын чиг хандлагыг танилцуулах, дижитал шинэчлэл, тогтвортой санхүүжилтийн чиглэлээр мэргэжлийн чадавхийг нэмэгдүүлэх, зах зээлийн оролцогчид болон бодлого боловсруулагчдын ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой цогц арга хэмжээ боллоо.

The background of the page is a complex, abstract geometric pattern composed of numerous overlapping, semi-transparent polygons in shades of grey and white, creating a crystalline or faceted appearance. A bright light source from the left creates a lens flare effect across the scene.

3.1. Биржийн бус зах зээл

3.1.1. Блокчэйнд суурилсан арилжаа

М-ОТС АРИЛЖААНЫ ПЛАТФОРМЫГ БЛОКЧЭЙНд СУУРИЛСАН АРИЛЖААНЫ СИСТЕМ БОЛГОЖ ШИНЭЧИЛЛЭЭ

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны удирдлага дор хөгжүүлсэн М-ОТС платформ нь Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 11 дүгээр сард блокчэйн үнэт цаасны арилжааг Сэндбоксын зохицуулалтын орчинд туршин хэрэгжүүлэх зөвшөөрөл авсан. Тус платформыг Сэндбоксын зохицуулалттай орчинд 1 жилийн хугацаанд амжилттай туршиж, Сэндбоксын зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 21 тоот зөвлөмжийн дагуу сэндбокс орчноос гарах бэлтгэл ажлыг хангах 6 сарын төлөвлөгөөг хэрэгжүүлсний үндсэн дээр, 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр сэндбокс зохицуулалтын орчноос гарах хүсэлтийг хүргүүлсэн.

Уг хүсэлтийг үндэслэж 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан Сэндбокс зөвлөлийн ээлжит хуралдаанаар блокчэйнд суурилсан арилжааны системийг сэндбоксын зохицуулалтын орчинд амжилттай туршсан гэж дүгнэж, тухайн системийг сэндбоксын орчноос албан ёсоор гаргах шийдвэрийг баталлаа.

Үүний үр дүнд Биржийн бус зах зээлийн арилжааг ажлын өдрүүдэд 24/5 тасралтгүй явуулах төлбөр тооцоог цаг алдалгүй автоматаар 1 минутын дотор гүйцэтгэх боломжтой болсон бөгөөд улмаар өнгөрсөн 3 сарын хугацаанд хоёрдогч зах зээлийн арилжааны идэвх 40% нэмэгдсэн. Цаашлаад ББЗЗ-ийн арилжаа тасралтгүй ажиллах горимд шилжсэнээр зах зээлийн идэвх улам нэмэгдэх хүлээлттэй байгаа юм.



3.1.2. Биржийн бус зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэв

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫН АРИЛЖААГ ЗОХИЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 07 дугаар тоот тогтоолоор “Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам” батлагдсантай холбогдуулан Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 25/20 дугаар тогтоолоор “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам”-д нэмэлт, өөрчлөлт орууллаа.

Уг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хадгаламжийн сертификатыг биржийн бус зах зээлд бүртгэх, арилжих зохицуулалтыг журамд тусгаснаар зах зээлийн оролцогчдод шинэ төрлийн үнэт цаасыг арилжаалах эрх зүйн боломж бүрдэж, биржийн бус зах зээлийн бүтээгдэхүүний хүрээ өргөжсөн ач холбогдолтой болов.



3.1.3. БОНДЫН ЗАХЫН ИХ ХУРАЛДАЙ 2025

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙГ ТАНИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ ХҮРЭЭНД




Биржийн бус зах зээлийн бүртгэлийн нэгж нь 2025 онд хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах боломжийг бизнесийн орчинд таниулах зорилгоор сургалт, илтгэлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллалаа. Үүнд “Бондын захын их хуралдай 2025” арга хэмжээ, “Бизнесээ Томруулъя” жижиг, дунд бизнес эрхлэгчдийн чуулга уулзалт, мөн “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн ментор клуб” ТББ-ийн гишүүдэд зориулсан арга хэмжээнүүд багтав.

Эдгээр арга хэмжээний хүрээнд “Хөрөнгийн зах зээл дээр санхүүжилт татах боломжууд” сэдвээр илтгэл, сургалт зохион байгуулж, хөрөнгө оруулалт татах, бизнесээ өргөжүүлэх, санхүүжилтийн шинэ эх үүсвэр эрэлхийлж буй аж ахуйн нэгжүүдэд бодит мэдээлэл, зөвлөмж хүргүүлсэн. Энэхүү үйл ажиллагаа нь бизнес эрхлэгчдийг хөрөнгийн зах зээлтэй холбох, биржийн бус зах зээлийн бүтээгдэхүүн, боломжийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

3.1.4. ББЗЗ-ийн оролцогчдын үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт

ББЗЗ-Н ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ БОЛОН ШУУД ОРОЛЦОГЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙЛЭЭ



Удирдах зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 25/34 дугаартай тогтоолоор баталсан “Биржийн бус зах зээлийн үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх удирдамж”-ийн дагуу биржийн бус зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд газар дээрх болон цахим хэлбэрээр хяналт, шалгалт зохион байгууллаа.

Хяналт, шалгалтад биржийн бус зах зээл дээр үнэт цаас гаргахад зуучлалын үйлчилгээ үзүүлсэн андеррайтерийн эрхтэй 12, брокер, дилерийн эрхтэй 20 компани, мөн биржийн бус зах зээл дээр олон удаа өрийн хэрэгсэл гаргасан, нөхцөлтэй бүртгэгдсэн 13 үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа хамрагдав.

Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр ажлын хэсгээс үүрэг даалгавар, мэргэжлийн зөвлөгөөг тухай бүр хүргүүлэн ажилласан. Шалгалтын нэгдсэн тайланг Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалт, зохицуулалтын газарт албан ёсоор хүргүүллээ.

3.1.5. ББЗЗ-ийн үнэт цаасны бүртгэлийн журмын шинэчлэл, хэрэгжилт

ШИНЭ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАНИЛЦУУЛЖ, ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДАЙ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

МҮЦАЭХ-ны Удирдах зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 24/47 дугаар тоот тогтоолоор баталсан “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 52 дугаар тоот тушаалаар батламжилсан.

Үүнтэй холбогдуулан уг шинэчилсэн журам 2025 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд нэмэлт, өөрчлөлттэй холбоотой мэдээллийг хүргэх зорилгоор 2025 оны 2 дугаар сарын 21-ний өдөр биржийн бус зах зээлийн шууд оролцогч байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, журмын хэрэгжилт, практик хэрэглээний талаар санал солилцлоо.





3.1.6. Арилжааны тайлан

Биржийн бус зах зээлд 2025 онд 125 компанийн, 150 өрийн хэрэгсэл бүртгэгдлээ. Үүнээс 2,385.1 тэрбум төгрөгийн өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 1,589.6 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна. Харин ам.доллараар 84.0 сая ам.доллар бүртгэгдэж, 63.9 сая ам.доллар татан төвлөрүүлээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад төгрөгөөр бүртгэгдсэн бонд 33.7 хувиар өссөн бол, ам.доллараар бүртгэгдсэн бонд 9.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин 2022-2025 оны хугацаанд бүртгэгдсэн бондын дүнгийн жилийн дундаж өсөлт төгрөгийн хувьд 47.9%, ам.долларын хувьд 6.1% байна.



Он	Бүртгэгдсэн дүн /тэрбум ₮/		Татан төвлөрүүлсэн дүн /тэрбум ₮/		Он	Бүртгэгдсэн дүн /сая \$/		Татан төвлөрүүлсэн дүн /сая \$/	
	Бүртгэгдсэн дүн	%	Татан төвлөрүүлсэн дүн	%		Бүртгэгдсэн дүн	%	Татан төвлөрүүлсэн дүн	%
2022	734.6		655.9		2022	0		0	
2023	1010.6	37.6	829.8	26.5	2023	74.5		33.5	
2024	1783.6	46.5	1670.6	101.3	2024	92.4	24.0	72	114.9
2025	2385.1	33.7	1589.6	-4.9	2025	84	-9.1	63.9	-11.3



3.1.7. Бүртгэгдсэн үнийн дүн салбараар

Тайлант хугацаанд бүртгэгдсэн бондыг салбараар ангилан үзвэл нийт бондын 39.9 хувь нь санхүүгийн салбарт хамаарч байна. Санхүүгийн салбарын бондын 63.2 хувийг Банк бус санхүүгийн байгууллага, барьцаалан зээлдүүлэх газар 30.2 хувь, хөрөнгө оруулалтын компани 6.5 хувь, Үнэт цаасны компани 0.1 хувийг эзэлж байна.


Нийт салбар	Үнийн дүн / тэрбум.төг/
Барилга, зам тээвэр	524.6
Боловсрол, эрүүл мэнд	20.0
Мэдээлэл, холбоо	2.5
Санхүү	950.7
Уул уурхай, олборлолт	302.0
Үйлдвэрлэл	48.3
Хөдөө аж ахуй	6.5
Худалдаа, үйлчилгээ	134.7
Эрчим хүч	378.7
Бусад	17.1
Нийт	2,385.1



3.1.8. Бүртгэгдсэн өрийн хэрэгсэл хугацаагаар

Тайлант хугацаанд 6-12 сарын хугацаатай бонд 61 хувь, 18 сарын хугацаатай бонд 22 хувь, 24 сарын хугацаатай бонд 16 хувь, 36 ба түүнээс дээш сарын хугацаатай бонд 1 хувийг тус тус бүрдүүллээ.

Хугацаа	Эзлэх хувь
6-12 сар	61
18 сар	22
24 сар	16
36 ба түүнээс дээш	1




3.1.9. ӨГӨӨЖИЙН МУРУЙ

Идэвхтэй байгаа В самбарын хувьд 6 сарын дараа төлөгдөх бондын өгөөжтэй харьцуулахад 24 сарын дараа төлөгдөх бондын өгөөж 0.16 нэгжээр өндөр байна. Харин С самбарын хувьд 24 сарын дараа төлөгдөх бондын өгөөж 6 сарын дараа төлөгдөх бондын өгөөжөөс 1.85 нэгжээр өндөр байна.

*Хөрөнгө оруулагчтай харилцан тохиролцон хүүг багаар тооцсон компаниудыг хасаж тооцсон болно.


В самбар

6 сар	19.78%	18.90%
12 сар	19.33%	19.50%
18 сар	19.93%	20.10%
24 сар	19.94%	19.90%



С самбар

6 сар	18.35%	18.90%
12 сар	18.64%	18.60%
18 сар	19.70%	19.30%
24 сар	20.20%	20.60%



3.1.10. ЭРГЭН ТӨЛӨЛТ

Тайлант хугацаанд төгрөгөөр


771.9

тэрбум,

ам.доллороор

37.4

сая эргэн төлөлт хийгдсэн байна.

A large, faceted diamond is the central focus of the page, set against a dark background. The diamond's facets are highlighted with light, creating a complex geometric pattern of triangles and polygons. A bright light source from the left creates a lens flare effect across the diamond's surface.

3.2. Эрх олгох сургалт

3.2.1. Эрх олгох сургалт болон шалгалт

ТАНХИМ, ЦАХИМ ХОСОЛСОН СУРГАЛТ БОЛОН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЦАХИМ СУРГАЛТЫН ХЭРЭГЖИЛТ

2025 оны эхний удаагийн мэргэжлийн сургалтыг 4 дүгээр сарын 7-ноос 4 дүгээр сарын 25-ны өдрүүдэд танхим болон цахим хэлбэрээр (e.masd.mn, Zoom meetings) зохион байгуулж, нийт 179 мэргэжилтэн хамрагдлаа. Сургалтын үндсэн шалгалтыг 2025 оны 4 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд танхимаар, давтан шалгалтыг 5 дугаар сарын 1, 4-ний өдрүүдэд танхимаар болон цахимаар зохион байгуулав.

Мөн 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулсан ээлжит сургалтад нийт 200 мэргэжилтэн хамрагдсан бөгөөд сургалт 11 дүгээр сарын 3-наас 11 дүгээр сарын 21-ний өдрүүдэд танхим болон цахимаар (e.masd.mn, Zoom meetings) явагдлаа. Тус сургалтын үндсэн шалгалтыг 11 дүгээр сарын 24-ний өдөр, давтан шалгалтыг 11 дүгээр сарын 27, 28-ний өдрүүдэд танхимаар зохион байгуулсан.

Үүнээс гадна Компанийн засаглалын сургалтыг бүрэн цахим хэлбэрээр, 24/7 — хаанаас ч, хэзээ ч үзэх боломжтой байдлаар e.masd.mn сургалтын платформоор зохион байгуулж, нийт 153 хүн хамрагдан сургалтаа амжилттай дүүргэж, гэрчилгээгээ авсан байна.

Дээрх сургалтууд нь мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, зах зээлийн оролцогчдын мэргэжлийн чадавхыг бэхжүүлэхэд бодит үр дүн үзүүлсэн ач холбогдолтой үйл ажиллагаа боллоо.



3.2.2. Тендер

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА, ТЕСТИЙН НОМ БЭЛТГЭХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫГ СОНГОХ ТЕНДЕР ЗАРЛАЛАА

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо (МҮЦАЭХ) нь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн, хөрөнгийн зах зээлд ажиллах мэргэжилтэнд эрх олгох шалгалтад зориулсан сургалтын гарын авлага болон жишиг тестийн сан боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр нээлттэй сонгон шалгаруулалт зарласан.

Сонгон шалгаруулалтын нийт төсөв 150 сая төгрөг байсан бөгөөд тендерийн материалыг 2025 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 12:00 цаг хүртэл МҮЦАЭХ-ийн байранд хүлээн авч, мөн өдөр 16:00 цагт саналуудыг нээсэн.

Оролцогчдоос хөрөнгийн зах зээлийн чиглэлээр их, дээд сургуульд 2 ба түүнээс дээш жил багшилсан, Монголын хөрөнгийн зах зээлд 2 ба түүнээс дээш жил ажилласан, мөн хууль, эрх зүй, зохицуулалтын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх гэсэн шалгууруудыг тавьсан.

Сонгон шалгаруулалтад МУИС-ийн Бизнесийн сургууль, “Актив финкрафт” ХХК, “Тривендү энд Ко” ХХК, “Тасралтгүй боловсрол судалгааны институт” ХХК саналаа ирүүлж, эдгээр саналуудыг МҮЦАЭХ-ны дэргэдэх Боловсролын дэд хороогоор хэлэлцсэний үр дүнд “Тривендү энд Ко” ХХК ажлыг гүйцэтгэхээр сонгогдов.

3.3. Дотоод хяналт

3.3.1. МҮЦАЭХ-ЫН ДОТООД ХЯНАЛТ

МҮЦАЭХ-НЫ ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛЛАА

МҮЦАЭХ-ны дотоод хяналтын 2025 оны төлөвлөгөөг Хяналтын зөвлөлийн 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцэн, 25/01 тоот тогтоолоор батлав.

Уг төлөвлөгөөнд Гишүүдийн үүргийн биелэлтийг хянах, сургалтын зохион байгуулалт, үр дүнг үнэлэх, санхүүгийн хяналт, Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны хяналт, гишүүдийн лиценз, үйл ажиллагааны зөвшөөрлийн хяналт, тайлагнах зэрэг төлөвлөгөөг оруулж баталсны дагуу дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

3.3.2. Гишүүдийн үүргийн биелэлт

ГИШҮҮДИЙН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТЭД ТОГТМОЛ ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАА

Холбоо нь гишүүн байгууллагуудаас хууль тогтоомжид заасан тайлан, мэдээллийг улирал тутам хүлээн авч, тэдгээрийн үүргийн биелэлтийг хянах ажлыг тогтмол хэрэгжүүлж ажиллалаа. Хяналтын хүрээнд нэгтгэсэн тайлан, мэдээллийг зохицуулагч байгууллагад тогтмол хүргүүлсэн.

Мөн Холбооны 13 гишүүн байгууллагад газар дээрх хяналт, шалгалт хийж, 24 гишүүн байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд үндэслэн төлбөрийн чадварын шинжилгээг гүйцэтгэн ажилласан. Энэхүү үйл ажиллагаа нь гишүүдийн үйл ажиллагааны сахилга, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой байв.

3.3.3. Сургалтын зохион байгуулалт, үр дүнгийн үнэлгээний хяналт

СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧАНАРЫГ ҮНЭЛЭН САЙЖРУУЛЛАА

Сургалтын зохион байгуулалт, үр дүнг үнэлэх зорилгоор 2025 онд зохион байгуулсан эрх олгох шалгалт бүхий хоёр сургалтын дараа суралцагчдаас үнэлгээ, санал хүсэлт авч, гарсан үр дүнг тухай бүрд нь нэгтгэн дүгнэв.

Үнэлгээний дүнд үндэслэн сургалтын зохион байгуулалт, агуулга, арга зүйг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

3.3.4. Санхүүгийн үйл ажиллагааны хяналт

САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВЬЖ, ХӨНДЛӨНГИЙН АУДИТ ХИЙЛЭЭ

Санхүүгийн төсвийн гүйцэтгэл, хэтрэлтийг хянаж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж, холбооны санхүүгийн үйл ажиллагааг ил тод, хариуцлагатай байлгах, төсвийн үр ашигтай зарцуулалтыг хангах зорилгоор хөндлөнгийн санхүүгийн аудитын дүгнэлт гаргуулан ажиллав.

Аудитын хүрээнд илэрсэн зөрчил, эрсдэлийг тодорхойлон, тэдгээрийг арилгах, дахин давтагдахаас сэргийлэх чиглэлээр шаардлагатай засах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.



3.3.5. Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны хяналт

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Биржийн бус зах зээл дээрх үнэт цаасны арилжааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй зохицуулалтын хэрэгжилтийг хянах, мөн үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох зорилгоор тухайн жилийн хугацаанд хоёр удаа хяналт хийлээ.

Хяналтын явцад арилжааны үйл ажиллагаанд илэрч болзошгүй эрсдэл, зохицуулалтын сул талыг тодорхойлж, цаашид анхаарах асуудал, сайжруулах чиглэлүүдийг санал зөвлөмж өгсөн нь зах зээлийн тогтвортой, хэвийн үйл ажиллагааг хангахад ач холбогдолтой байв.



3.3.6. Мэргэжилтны ёс зүйн өдөрлөг

МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Мэргэжлийн ёс зүйн өдөрлөгийг Холбооны гишүүн байгууллагуудын удирдлага болон холбогдох ажилтнуудад зориулан зохион байгуулж, ёс зүйн шинэчлэгдсэн баримт бичгүүдийг танилцуулах, хэрэгжилтийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглүүлэв.

Өдөрлөгийн хүрээнд дараах агуулгыг албан ёсоор танилцуулж, тайлбарлалаа.

Үүнд:

- “Мэргэжлийн ажил, үйлчилгээ үзүүлэгчдийн баримтлах ёс зүйн дүрэм”
- “Холбоо болон түүний гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, гомдол, маргааныг хянан шийдвэрлэх журам”

Мөн мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчим, зан төлөв, мэдээллийн нууцлал, сонирхлын зөрчил-тэй холбоотой ойлголтыг сайжруулах, гишүүн байгууллагуудын хооронд үүссэн гомдол, маргааныг шалгах, шийдвэрлэх шинэ шат дараалал, гомдол гаргах боломж болон сахилгын арга хэмжээ авах үндэслэлүүдийг дэлгэрэнгүй тайлбарлав.

Энэхүү өдөрлөг нь гишүүн байгууллагуудын ёс зүйн соёлыг бэхжүүлэх, журам, дүрмийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.



Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1р хороо,
Энхтайваны өргөн чөлөө Express tower 11-01



70143339 (Биржийн бус зах зээл)
70133339 (Гишүүнчлэл)
70123339 (Сургалт)



masd.mn